

ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН  
САЙНЦАГААН СУМАНД ХАМААРАЛТАЙ ЗААЛТЫН ХЭРЭГЖИЛТ

САЙНЦАГААН СУМ

2022.06.15

Шийдвэр Д/д	Заалт Д/д	Шийдвэрийн нэр, огноо, дугаар	Холбогдох заалтын агуулга	Биелэлт (Хариуцах эзэн)	Үнэлгээ (хүчингүй болсон, хяналтаас хасуулах тухай санал )
МУ-ын хууль					
1	1	Ашигт малтмалын тухай /Шинэчилсэн найруулга/ 2006-07-08 Дугаар 2006.08.26	43.3.. Энэ хуулийн 43.2-т заасан төлбөрийг тухайн сум, дүүргийн төсөвт төвлөрүүлж хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байр шинээр бий болгох, боловсролын болон эрүүл мэндийн салбарт зарцуулах бөгөөд энэ талаархи журмыг сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал батална.(43.1.Ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч болон тэдгээрийн туслан гүйцэтгэгч нь Монгол Улсын иргэдийг ажлын байраар хангах үүрэг хүлээх бөгөөд тухайн хуулийн этгээдэд ажиллагсдын 10-аас дээшгүй хувь нь гадаадын иргэн байж болно. 43.2.Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь гадаадын иргэдийг энэ хуулийн 43.1-д зааснаас илүү хэмжээгээр авч ажиллуулсан тохиолдолд ажлын байр тутамд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 10 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төлбөрийг сар бүр төлнө.)	2022 оны 3 дугаар сарын 25-ны өдөр Монголын Алт/МАК/ ХХК-аас ажлын байрны нээлттэй өдөрлөг зохион байгуулж 120 иргэнийг хамруулж 19 иргэнийг байнгын ажлын байранд зуулчиллаа.	70
2	2	Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай /Шинэчилсэн найруулга/ 2016-12-22 Дугаар 2017.02.01	18.1.1. Харьяалах нутаг дэвсгэртээ гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хохирогчийг хамгаалах талаар хөтөлбөр баталж, хэрэгжилтэд хяналт тавих; (18.1.Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх талаар дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:)	Сумын ГХУСАЗСЗөвлөл, сумын хамтарсан баг, Цагдаагийн газартай хамтран гэр бүлийн хүчирхийлэлгүй баг аяныг зохион байгууллаа. Аяны хүрээнд 30 гэр бүлийн хүчирхийллийн асуудалтай өрхтэй ажиллаж, сургалт, нөлөөллийн арга хэмжээ, хяналт шалгалтыг зохион байгуулж, нийгмийн ажлын холбон зуучлах үйлчилгээ үзүүлж, ААнийгэмлэг, Гэрэлтдэг ертөнц ТББ-тай хамтран ажиллалаа. Гэр бүлийн баярын өдрийг тохиолдуулан	100

				Цагдаагийн газартай хамтран “Гэр бүлээ хайрлая” өдөрлөг зохион байгуулж, сургалт, нөлөөллийн тайван жагсаалыг ТББ, сумын ахмадынн хороотой хамтран зохион байгуулж, 300 төрийн албан хаагч, ахмад настан, ЕБС-ийн хүүхдүүд оролцлоо.	
	3		18.1.2..Засаг даргын өргөн мэдүүлснээр харьяалах нутаг дэвсгэртээ хэрэгжүүлэх гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх үйл ажиллагааны зардлыг тухайн орон нутгийн төсөвт тусган батлах, гүйцэтгэлийн тайланг хэлэлцэх; (18.1.Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх талаар дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:)	Сумын ГХУСАЗСалбар зөвлөлтэй хамтран Гэр бүлийн хүчирхийлэлгүй баг 2 сарын аян зохион байгуулж , 2.0 сая төгрөг зарцууллаа.	100
	4		19.1.1.. Харьяалах нутаг дэвсгэртээ гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль тогтоомжийг сурталчлах, хэрэгжүүлэх арга хэмжээг зохион байгуулах, хүчирхийллийн шалтгаан, нөхцөлийг тогтоох, арилгах арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх; (19.1.Бүх шатны Засаг дарга гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх талаар дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:)	Оюуны гэгээ ТББ-тай хамтран “Баатар хотын бас миний түүх” сэдэвт сургалтыг ЕБС-ийн ахлах ангийн 30 хүүхдэд зохион байгуулж, сургагч хүүхэд бэлтгэн ЕБС-ийн 1000 гаруй хүүхдэд тус сургалтыг СНА-тай хамтран зохион байгууллаа. Мандал сургууль эцэг эхийн дунд “Эцэг эхийн өдөрлөгийн 2022 оны 02 сарын 18-20 өдрүүдэд зохион байгуулж “Хүүхдийн хөгжилд эцэг эхийн оролцоо” сэдвээр сургалт зохион байгуулж нийт 725 эцэг эх хамрагдлаа. Мөн хүүхдийн эрхийн зөрчлөөс урьчилан сэргийлэх чиглэлээр 5-7-р ангийн нийт 145 сурагчид үе тэнгийн сургагч багш нараар думжуулан “Баатар хотын бас миний түүх” сэдэвт сургалтын зохион байгууллаа. ГБХЗХГ, Цагдаагийн газартай хамтран зохион байгуулсан Хүүхдийн эсрэг бэлгийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хүүхдийг бага наснаас нь хувийн орон зай, аюулгүй байдлын дүрэмд суралцуулах зорилготой "Миний биеийн аюулгүйн дүрэм" сургалтанд цэцэрлэгийн ахлах, бэлтгэл бүлгийн 346 хүүхэд хамрагдлаа.	100

	5		19.1.2.. Хамтарсан багийг нэгдсэн удирдлагаар хангаж, тогтвортой ажиллах нөхцөлийг бүрдүүлэх; (19.1.Бүх шатны Засаг дарга гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх талаар дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:)	Сумын ИТХ-ын 2021 оны 18 дугаар тогтоолоор Хамтарсан багийг шинэчлэн 36 хүний бүрэлдэхүүнтэй байгуулан 108 утаснаас ирүүлсэн 13 дуудлага, цагдаагийн 20 албан мэдэгдлийн дагуу нийгмийн ажлын үйлчилгээнд 32 хүүхдийг хамрууллаа. Хөдөөгийн багуудын өдөрлөг, Гэр бүлээ хайрлая өдөрлөг, Гэр бүлийн хүчирхийлэлгүй баг аян, Төрийн үйлчилгээний албан хаагчдын сургалт, Төлчин эмэгтэйчүүдийн чуулга уулзалт, арга хэмжээнүүдээр гэр бүлийн тогтвортой байдлыг хангах, эцэг эхийн үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэх, иргэд олон нийтэд гэр бүлийн боловсрол олгох, Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх зорилгоор “Гэр бүлийн хүчирхийллийн хор уршиг, ГБХ-ийн тухай хуулиар 900 гаруй иргэнд сургалт зохион байгуулж, 388 гарын авлага тараалаа.	100
	6		19.1.3.. Орон нутгийн төсвийн хөрөнгөөр нэг цэгийн үйлчилгээний төв, түр хамгаалах байр байгуулах саналаа иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлэх, гарсан шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах; (19.1.Бүх шатны Засаг дарга гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх талаар дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:)	Хамгаалах байртай болох асуудлаар сумын ГХУСАЗСЗөвлөл, хамтарсан баг холбогдох газруудад, хурал, чуулганд тогтмол санал бодлоо илэрхийлж, нөхцөл байдлаа илэрхийлсээр байна. Суманд хамгаалах байр байхгүй.	ҮБ
3	8	Төрийн албаны тухай /Шинэчилсэн найруулга/ 2017-12-07 Дугаар 2019.01.01	55.3. Төрийн байгууллага төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлнэ.	Төрийн албан хаагчдын нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн хүрээнд сумын хэмжээнд 14 зорилт, 22 арга бүхий төлөвлөгөөг гарган боловсруулан харъяа байгууллагад хүргүүлж 75.8%-тай хэрэгжүүллээ. Хөтөлбөрийн хүрээнд төсөвт байгууллагуудын албан хаагчид засгийн газрын 5, 382 дугаар тогтоолын дагуу үр дүн, ур чадварын урамшуулалд	70

				хамрагдахаас гадна байгууллагын дотоод журмаар 19 албан хаагч 12.3 сая төгрөгийн дэмжлэгт хамрагдлаа.	
4	9	Татварын ерөнхий хууль 2019-03-22 Дугаар 2020.01.01	8.1.. Татварын хувь, хэмжээг Улсын Их Хурал, түүний эрх олгосноор Засгийн газар болон аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал хууль тогтоомжийн дагуу тус тус тогтооно.	Тус хуульд заасны дагуу сумын ИТХ-аар малын тоо толгойн албан татвар /адуу-1500, Үхэр-0, Тэмээ-0, Хонь-400, Ямаа-500/, хог хаягдлын хураамжыг тус тус баталж мөрдөн ажиллаж байна.	70
УИХ-ын тогтоол					
5	10	Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 19, 20 дахь илтгэлийг хэлэлцсэнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай 2021-07-07 Дугаар 2021 №67	1.1.ж/. цар тахлын үед хүүхэд, зорилтот бүлгийн иргэдийн эрхийг хамгаалах, хүүхэд хамгааллын байцаагчийн тоог нэмэгдүүлэх, хүүхэд хамгааллын асуудалд нэн шаардлагатай санхүүжилтийг шийдвэрлэх, аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга нар харьяалах нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, хүүхдийн эрхийг хамгаалах чиглэлээр хуулиар хүлээсэн үүргээ үр дүнтэй хэрэгжүүлэхэд шаардагдах төсвийг ямар ч нөхцөлд хасахгүйгээр, цогц байдлаар төсөвлөх, шаардлагатай тохиолдолд төсвийг нэмэгдүүлэхэд чиглэсэн арга хэмжээг шуурхай авч хэрэгжүүлэх; (1/Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх үйл ажиллагаанд хүний эрхийг хангах, хамгаалах чиглэлээр:)	Сумын ЕБ-ын 5 сургуульд 2 сэтгэлзүйч, 6 нийгмийн ажилтан, суманд 2 хэсгийн байцаагч ажиллаж, хүүхэд хамгааллын нийгмийн ажлын үйлчилгээг үзүүлж байна. Сумын ГХУСАЗСЗөвлөл, Хамтарсан баг хамтран Хүүхэд миний бодлоор гар зураг, жүжигчилсэн тоглолтын уралдааныг ЕБС-ийн хүүхдүүдийн дунд зохион байгуулж, 1.0 сая төгрөг зарцууллаа. Гэр бүлийн хүчирхийлэлгүй баг аяны хүрээнд төвийн 4 баг гэр бүлийн хүчирхийллийн эсрэг нөлөөллийн зурагт хана бүтээж, 600000 төгрөг зарцууллаа.	70
УИХ-ын байнгын хорооны тогтоол					
6	11	“Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 16 дахь илтгэл”-ийг хэлэлцсэнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай 2018-01-31 Дугаар 2018	3.8.. Бүх шатны Засаг дарга гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, хүүхдийн эрхийг хамгаалах чиглэлээр хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэх, дээрх үйл ажиллагаанд шаардагдах төсөв, хөрөнгийг шийдвэрлэх, дээрх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагыг дэмжих, урьдчилан сэргийлэх ажилд иргэд, олон нийтийг татан оролцуулахад анхаарах, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл хамтарсан багийн үйл ажиллагаанд тогтмол хяналт тавьж ажиллах, хамтарсан багийн гишүүдийг чадавхжуулах, хорооны цагдаагийн алба хаагч, нийгмийн ажилтны орон тоог нэмэгдүүлэх, мэргэжлийн нийгмийн ажилтныг ажиллуулах.	Үйзэн , Далай багийн уулын тахилгын наадам зохион байгуулахтай холбогдуулан хурдан морины уралдааны үед уралдаанч хүүхдийн аюулгүй байдлыг хангах Хамтарсан багийг сумын засаг даргын А/141 дугаар захирамжаар байгуулан , 2 насны хурдан морьны уралдааны явцад давхардсан тоогоор 62 уралдаанч хүүхдийн эрхийг хамгаалж ажиллалаа. Сумын ГХУСАЗСЗөвлөлөөс санаачлан “Соёлтой жолооч-Соёлтой зорчигч” 14 хоногийн аян зохион байгуулж, Цагдаагийн газар, авто тээврийн газар, авто сургуулиуд, ЕБС-иуд,	100

		№02 ХЗБХ		<p>СӨБ-ын байгууллагуудтай хамтран 13 төрлийн сургалт, уралдаан, нөлөөллийн арга хэмжээнүүдийг зохион байгуулж, 6000 гаруй иргэн, хүүхдийг хамрууллаа. Мөн Зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх чиглэлээр 2022 оны ОНХСангийн хөрөнгөөр гэр хороолол болон төвийн замуудад стандартын шаардлага хангасан 8 цэгт хурд сааруулагч байршуулж 16.0 сая төгрөг зарцууллаа. ХТГ-аас төвийн замуудын явган хүний гарцны тэмдэглэгээг сэргээн сайжрууллаа.</p> <p>Сумын ЕБ-ын 5 сургуульд 2 сэтгэлзүйч, 6 нийгмийн ажилтан, суманд 2 хэсгийн байцаагч ажиллаж, хүүхэд хамгааллын нийгмийн ажлын үйлчилгээг үзүүлж байна.</p>	
Ерөнхийлөгчийн зарлиг					
7	12	Монгол бичгийн хэрэглээг нэмэгдүүлэх ажлыг эрчимжүүлэх туай 2018-05-23 Дугаар 2018_46	3.. Албан байгууллага, аж ахуйн нэгж, барилга байгууламж, гудамж, талбайн нэр хаяг, бүтээгдэхүүний шошго, бэлгэ тэмдэг, зар сурталчилгаа зэргийг үндэсний бичгээр бичиж хэвшүүлэх ажлыг зохион байгуулах; үндэсний бичгийн хэрэглээг нэмэгдүүлж, түгээн дэлгэрүүлэхэд чиглэсэн уг үйл ажиллагаа, аливаа идэвх санаачилгыг хөхиүлэн дэмжиж, урамшуулж ажиллахыг бүх шатны Засаг дарга нар, холбогдох төрийн байгууллагуудад чиглэл болгосугай.	Харъяа 7 байгууллага шинээр Монгол бичгээр хаяг хийж байршуулан 9.908.000 сая төгрөг зарцууллаа. Сумын төсөвт байгууллагууд 100% монгол бичгээр хаягжууллаа. Байгууллага бүр албан өрөө тасалгааны хаяг, албан хаагчдын нэрийг хос бичгээр бичиж байршууллаа.	100
	13		4.. Энэхүү зарлигт дурдсан ажлуудад болон монгол хэл, бичиг үсгээ сурч судлах, өвлөх, өвлүүлэх, эзэмших, хэрэглэх, хамгаалах, хөгжүүлэх талаар идэвх санаачилга гарган ажиллахыг иргэд, олон нийт, эрдэмтэн судлаачид, шинжлэх ухааны ба хэвлэл мэдээллийн байгууллага, төрийн ба төрийн бус байгууллагуудад уриалсугай.	Үндэсний бичиг үсгийн баяр"-ын хүрээнд Алдар гавьяат уран зохиолч С.Буяннэмэхийн 120 жилийн ойг тохиолдуулан сумын хэлний бодлогын салбар зөвлөл, аймгийн төв номын сантай хамтран Монгол бичгийн Аймгийн Тэргүүний хурдан уншигч уралдаан 12, Цэгцбилиг сургуультай хамтран Их сорилго олимпиадыг зохион байгуулж 6-12-р ангийн ангилалд 507 сурагч хамрагдаж, 34 суралцагч шагналт байранд шалгарч, Шилдэг сургуулиар Цэгцбилиг сурууль	70

				шалгарлаа. Дээрх арга хэмжээнүүдэд 1.6 сая төгрөг зарцууллаа. Мөн ЕБСургуулиуд аймаг, сумын хэлний бодлогын зөвлөлтэй хамтран ТАХ-ийн үндэсний бичгийн олимпиад, цахим бичвэр, бийрийн бичлэгийн уралдаан, “Үндэсний бичиг-Өв соёл” тик ток уралдаануудыг зохион байгуулж 130 багш, суралцагч хамрагдлаа.	
8	14	Засгийн газарт чиглэл өгөх тухай 2022-04-05 Дугаар 2022_43	1.4. Төрийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдээс зохион байгуулж буй албан ёсны баяр, ёслолын арга хэмжээ, хүлээн авалтад өндөр хатуулагатай этилийн спирт агуулсан архи, согтууруулах ундааг хэрэглэхийг бүрмөсөн хориглох;	Ерөнхийлөгчийн зарлигийг сумын харъяа төсөвт байгууллагууд хүргүүлж хэрэгжүүлж ажиллахыг мөрдлөгө болгон ажиллах зөвлөмж өглөө.	70
	15		2. Нийт иргэн, аж ахуй нэгж, байгууллага архи, согтууруулах ундааны хэрэглээ, түүнээс үүдэлтэй эрүүл мэнд, нийгэм, эдийн засгийн сөрөг үр дагаврыг бууруулахад санаачилгатай оролцох, баяр ёслол, тэмдэглэлт өдөр, ажлын байранд өндөр хатуулагтай этилийн спирт агуулсан архи, согтууруулах ундааг хэрэглэхгүй байхыг уриалсугай.	Ерөнхийлөгчийн зарлигийг сумын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг архи согтууруулах ундаа худалдан борлуулдаг 28 ААНэгж, иргэнд тус зарлигыг хүргүүллээ.	70
ЗГ-ын тогтоол					
9	16	журам шинэчлэн батлах тухай / Угийн бичиг хөтлөх журам/ 2007-10-03 Дугаар 2007_257	2.. Угийн бичиг хөтлөх үлгэрчилсэн загварыг 2008 онд багтаан боловсруулж хэрэгжүүлэхийг Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд Ө.Энхтүвшинд даалгасугай. Хавсралт: 1.4. Аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны Засаг дарга харьяа нутаг дэвсгэрийн нийт өрхийн хэмжээнд өрх бүрийг угийн бичиг хөтлүүлэх ажлыг хариуцан зохион байгуулах үүрэг хүлээнэ.	“Ураг төрлөө мэдэж, угийн бичгээ хөтөлцгөөе-2” аяныг төсөвт байгууллага, иргэдийн дунд 6 сарын хугацаатай зохион байгуулахаар удирдамж боловсрууллаа. 5011 өрхөөс 2021 онд 296 өрх буюу 6% шинээр угийн бичиг хөтлөж эхлэн одоогоор 2604 өрх буюу 55% нь угийн бичигтэй болсон байна.	70
10	17	Төрийн үйлчилгээний талаар авах зарим арга хэмжээний тухай 2019-04-17 Дугаар 2019_149	3.. Иргэн, хуулийн этгээдэд төрийн зарим үйлчилгээг цахим хэлбэрээр үзүүлэхэд төрийн мэдээллийн сангаас гарах боломжтой лавлагаа, мэдээллийг шаардахгүй байх зарчмыг баримтлан технологийн дэвшлийг ашиглаж төрийн мэдээлэл солилцооны “ХУР” системд хандан авах замаар шийдвэрлэх, “Үйлчилгээний нэгдсэн төв”-д ажиллах байгууллагын албан хаагчдын орон тооны дээд хязгаарыг батлагдсан төсөвтөө багтаан шийдвэрлэхийг холбогдох сайд, Засгийн газрын агентлагийн дарга,	Иргэдэд e-mongolia төрийн үйлчилгээний цахим системийн чанар хүртээмжийг 112 иргэнд 56 төрлийн мэдээлэл лавлагаа хүргэлээ.	100

			аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгаж, Шүүхийн ерөнхий зөвлөл (Н.Лүндэндорж)-д зөвлөсүгэй.		
11	18	Мал аж ахуйн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэх талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 2020-01-15 Дугаар 2020_18	4.. Сумдад малын гаралтай түүхий эдийг бэлтгэх, хүлээн авах, стандартын дагуу ангилан ялгалт болон чанарын хамгаалалт хийж, зориулалтын дагуу хадгалах, тээвэрлэх, борлуулах сүлжээг хоршоодод тулгуурлан бий болгох талаар холбогдох арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ч.Улаан, аймгийн Засаг дарга нарт даалгасугай.	2022 оны 01 сараас эхлэн хоршоо хөгжүүлэх сангийн журам хэрэгжиж эхэлсэн бөгөөд одоогоор ХХСангийн дэмжлэгт малын гаралтай түүхий эдийн хоршоо үйл ажиллагаа явуулаагүй байна.	ҮБ

**Хэрэгжилтийн дундаж хувь-84.0%**